

ХБ-9



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2007 оны 4 сарын 19 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

“Хай Би Ойл” ХХК-ийн нийтэд санал
болгон гаргаж буй хувьцааг бүртгэх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7 дахь заалт, “Хай Би Ойл” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хай Би Ойл” ХХК нь 100 хувийн хувьцаа эзэмшигч Ө.Хүдрээгийн шийдвэрээр ХК болон өөрчлөгдөж, нийтэд санал болгон энгийн хувьцаа гаргаж байгаа тул уг компанийн нийт хувьцааны тоог нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5.0 сая ширхгээр тогтоож, үнэт цаасны зах зээлд арилжаалахаар зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл, Хөрөнгийн биржийн жагсаалт, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлд бүртгэхийг Ажлын алба /О.Ганбат/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Хай Би Ойл” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Ө.Хүдрээгийн эзэмшилд байгаа хаалттай компанийн хувьцааг хувьцаат компанийн нэг сая ширхэг хувьцаа болгон өмчлөх эрхийг баталгаажуулахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолд хавсаргасан товч танилцуулгын дагуу үнэт цаасыг нийтэд сурталчлан олон нийтийг бодитой мэдээллээр ханган, Хорооноос зөвшөөрөл авсаны дараа үнэт цаасыг арилжаалж эхлэхийг “Би Ди Сек” ХК /Д.Даянбилгүүн/-д, үнэт цаасны арилжааны тайланг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг ханган, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Хай Би Ойл” ХК /Ө.Хүдрээ/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол болон танилцуулгыг ажлын 3 хоногийн дотор Хорооны Вэб хуудсанд байршуулахыг Тамгын газар /Ж.Жадамбаа/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мониторинг, судалгааны газар /А.Тамир/-т даалгасугай.

ДАРГА

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

О.ГАНБАТ

УХА0419



Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн 4 дүгээр тогтоолын хавсралт

**НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ ҮНЭТ
ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

УХА00419

А. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАЛААР ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- | | |
|--|--|
| 1. Үнэт цаас гаргагчийн нэр | “Хай Би Ойл” ХХК |
| 2. Хаяг | УБ хот, СБД, 9-р хороо, 31-31 тоот |
| 3. Үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн | Шатахуун, авто тосны худалдаа, үйлдвэрлэл |
| 4. Захирлын Овог, нэр | Өлзийсайхан овогтой Хүдрээ |
| Хаяг | УБ хот, СБД, 9-р хороо, 31-31 тоот |
| Утас | 91919666 |
| 5. Компани охин болон хараат компанитай эсэх | Үгүй |
| 6. Компаний өмнө нь үнэт цаас гаргаж байсан эсэх | Үгүй |
| 7. Нийт хувьцааны хяналтын багцыг эзэмшигчдийн нэр, байршил, эзэмшил, хяналтын хувь хэмжээ | Ө.Хүдрээ, Гүйцэтгэх захирал
Эзэмшиж буй хувьцааны тоо 1,0 сая ш
Эзэмшиж буй хувь 20% |

Б. ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААР ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

СЗХ-ны 2007 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн .. дүгээр тогтоол

- | | |
|---|--|
| 1. Үнэт цаасны нэр | “Хай Би Ойл”ХК-ийн хувьцаа |
| 2. Үнэт цаасны төрөл | Энгийн |
| 3. Үнэт цаасны хэлбэр | Биет бус |
| 4. Санал болгож буй хүрээ | Олон нийтэд |
| 5. Үнэт цаасны нэрлэсэн үнэ буюу худалдахаар санал болгох анхны үнэ | 100 төгрөг |
| 6. Тоо ширхэг | 5 000 000 ширхэг |
| 7. Нийт үнийн дүн | 500 000 000 төгрөг |
| 8. Хаалттай компанийн хувьцаа хэрхэн хөрвөсөн | Хаалттай компанийн 100%-н хувьцаа буюу бүх хөрөнгө нээлттэй компанийн 1000000 ширхэг хувьцаа буюу 20% болон хөрвөсөн |
| 9. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулж дуусах огноо | 2007 оны 05 дугаар сарын 01-ний өдөр |



**“ХАЙ БИ ОЙЛ” компанийн
хувьцааг олон нийтэд санал болгон
гаргах танилцуулга**

Улаанбаатар хот
2006 он

10. Үнэт цаасны арилжаа
Хувьцааны арилжаа Брокер-дилерийн компаниудаар дамжуулан Монголын Хөрөнгийн Биржид явагдах ба нийлүүлэлт хийх хугацаа, хэмжээг компанийн ТУЗ тухай бүр шийдвэрлэж байна.
11. Хуримтлуулах хөрөнгийн зориулалт
Улаанбаатар хотод автомашины ажилласан тосыг боловсруулан сайн чанарын тос үйлдвэрлэх
12. Үнэт цаас эзэмшигчийн эрх
Үнэт цаас эзэмшигч нь хуулиар олгогдсон хувьцаа эзэмшигчийн түгээмэл эрхийг эдэлнэ.
13. Үнэт цаас эзэмшигчид учирч болох эрсдэл
Үнэт цаас эзэмшигч нь компанид оруулсан хөрөнгөөрөө хариуцлага хүлээх ба компанийн зүгээс хүлээж болох гол эрсдэл нь ажилласан тосны ханшийн өсөлт, үйлдвэрлэлийн технологийн горимыг чанд мөрдөн ажиллахтай холбогдон үүснэ.
14. Үнэт цаасны зуучлагч
Хаяг
Брокер дилер, андеррайтерын “БиДиСек” ХК
Чингэлтэй дүүрэг 6-р хороо Бага тойруу
26/1 байр
Утас 323411, Факс 976-11-313108
Утас: 321763, 313108, 99082846
15. Үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулгатай “БиДиСЕК” ХК дээр танилцаж болно.

В. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ

/мян.төг-өөр/

Балансын зүйл	Үлдэгдэл		
	2004 он	2005 он	2006 он
А.Хөрөнгө			
1.Эргэлтийн хөрөнгийн дүн	38,952,844.50	37,046,137.06	37,095,342.78
Мөнгөн хөрөнгө	9,972,844.50	95,196.58	10,546,691.88
Богино хугацаат хөрөнгө оруулалт			
Авлага		5,985,940.48	3,434,250.90
Бараа, бэлэн бүтээгдэхүүн	26,850,000.00	30,965,000.00	23,114,400.00
Үндсэн ба туслах материал	2,130,000.00		
Урьдчилж төлсөн тооцоо			
Бусад			
2.Биет хөрөнгийн дүн	16,926,000.00	24,426,000.00	24,786,000.00
Барилга, байгууламж			
Газар			
Машин, тоног төхөөрөмж	3,350,000.00	3,350,000.00	3,350,000.00
Тавилга, эд хогшил			
Хуримтлагдсан элэгдэл			
Бусад	13,576,000.00	21,076,000.00	21,436,000.00
3.Биет бус хөрөнгийн дүн			
4.Урт хугацаатай хөрөнгө оруулалт			
Нийт хөрөнгийн дүн	55,878,844.50	61,472,137.06	61,881,342.78
Б.Өр төлбөр ба эзэмшигчийн өмч			
1.Өр төлбөрийн дүн	6,077,305.09	16,639,133.37	16,943,290.52
Богино хугацаат өр төлбөр	6,077,305.09	16,639,133.37	16,943,290.52
Урт хугацаат өр төлбөр			
Үүнээс банкны хугацаа хэтэрсэн өр			
2.Өмчийн дүн	1,170,000.00	1,170,000.00	1,170,000.00
төрийн			
хувийн	1,170,000.00	1,170,000.00	1,170,000.00
3.Хувьцааны дүн			
Энгийн хувьцааны тоо ширхэг			
Нэрлэсэн үнэ			
Давуу эрхтэй хувьцааны тоо, ширхэг			
Нэрлэсэн үнэ			
Халаасны хувьцааны дүн			
4.Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	45,906,000.00	45,906,000.00	45,906,000.00
5.Хуримтлагдсан ашиг	2,725,539.42	(2,242,996.31)	(2,137,947.74)
6.Эзэмшигчийн өмчийн дүн	49,801,539.42	44,833,003.69	44,938,052.26
7.Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	55,878,844.51	61,472,137.06	61,881,342.78

Ногдол ашиг тараасан онууд

Нэгж хувьцаанд оногдуулсан ногдол ашиг /төг/

/Он бүрээр/

Үзүүлэлт	2004 он	2005 он	2006 он
1.Цэвэр борлуулалт	45,465,656.00	140,545,647.82	50,101,608.95
2.Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг	41,490,139.04	133,306,009.91	40,757,817.40
3.Үйл ажиллагааны зардал	769,000.00	9,464,436.60	9,220,205.00
4.Ашиг	2,725,539.42	(2,242,996.31)	105,048.57
5.Хувьцааны арилжааны дундаж ханш			
6.Хувьцааны дансны дундаж ханш			
7.Хувь нийлүүлэгчдийн тоо			
8.Хувьцааны төвлөрлийн хувь			


БҮРТГЭВ 03
Бүртгэл хяналтын
Алба 196

БҮРДҮҮЛСЭН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Өргөдөл
2. Үнэт цаас гаргагчийн талаар ерөнхий мэдээлэл
 3. "Хай Би Ойл"ХХК-ийн танилцуулга
 4. Хувьцаа гаргах тухай шийдвэр
 5. Компанийн дүрэм "Хай Би Ойл" ХХК
 6. Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 7. Газар эзэмших эрхийн гэрчилгээ
 8. Компанийн үндсэн хөрөнгийн үнэлгээ
 9. Компанийн санхүүгийн тайлан, тодруулга
 10. Банкны өр барагдуулах газрын тодорхойлолт
11. Үнэт цаасны тухай ерөнхий мэдээлэл
 12. Бизнес төлөвлөгөө, боловсруулах үйлдвэрийн төсөл
 13. Эрсдлийн шинжилгээ
 14. ХХК-ийн хувьцааг ХК-ийн хувьцаанд хөрвүүлсэн тооцоо
 15. "БиДиСЕК"ХК-ийн товч танилцуулга
 16. "БиДиСЕК"ХК-ийн аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар
 17. "БиДиСЕК"ХК-ийн дүрэм
18. Нэмэлт материалууд
 19. 2004 оны санхүүгийн тайлан, тодруулга
 20. Бүртгүүлэх зөвшөөрлийн хураамж төлсөн баримт
 21. Хувьцаа худалдан авах захиалгын хуудас

Нийт 135 хуудас

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



**НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАСАН ҮНЭТ ЦААСЫГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7-р зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн "Хай Би Ойл"ХХК-ийн 2006 оны 10-р сарын 30-ны өдрийн шийдвэрээр нийтэд санал болгон үнэт цаас гаргасныг бүртгүүлэхээр өргөдөл гаргаж байна.

1. Үнэт цаас гаргагчийн:

Оноосон нэр: "ХАЙ БИ ОЙЛ" ХХК
Хаяг: СБД 9-р хороо, 31-31 тоот

Улсын бүртгэлийн дугаар: 25/7178
регистр: 2615134

2. Үнэт цаасны зах зээл дээр зуучлах мэргэжлийн байгууллагын:

Оноосон нэр: "БиДиСек"ХК
Хаяг: Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 6-р
хороо Бага тойруу 21А байр 201 тоот

Улсын бүртгэлийн дугаар: 9010001030
Регистрийн дугаар: 2052482

3. Гаргах үнэт цаасны:

Нэр: "ХАЙ БИ ОЙЛ"ХК-ийн хувьцаа
Төрөл: Энгийн
Тоо хэмжээ: 5 000 000 ширхэг
Нэрлэсэн үнэ: 100 төгрөг
Санал болгох хүрээ: Олон нийтэд

4. Үнэт цаас гаргаж хуримтлуулах хөрөнгө нь Улаанбаатар хотод автомашины ажилласан тосны үйлдвэрийг байгуулан Монгол Улсын импортын тос, тосолгооны материалын тодорхой хэсгийг хангахад ашиглагдана.

5. Үнэт цаасны зах зээл дээр зуучлагч нь Үнэт цаас гаргагчийн арилжаанд зуучлан оролцож, үнэт цаасыг дээд зэргийн чармайлтаар зуучлан худалдан борлуулна.

6. Ирүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдлийг танилцуулгад бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:



/Ө.Хүдрээ, "Хай Би Ойл"ХХК-ийн захирал/

2006 оны 11 сарын 09 өдөр



НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ ҮНЭТ ЦААСНЫ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

А. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАЛААР ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Үнэт цаас гаргагчийн нэр	“ХАЙ БИ ОЙЛ” ХХК
2. Хаяг	УБ хот, СБД, 9-р хороо, 31-31 тоот
3. Үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл	Шатахуун, авто тосны худалдаа, үйлдвэрлэл
4. Захирлын Овог, нэр	Өлзийсайхан овогтой Хүдрээ
Хаяг	УБ хот, СБД, 9-р хороо, 31-31 тоот
Утас	91919666
5. Компани охин болон хараат компанитай эсэх	Үгүй
6. Компаний өмнө нь үнэт цаас гаргаж байсан эсэх	Үгүй
7. Нийт хувьцааны хяналтын багцыг эзэмшигчдийн нэр, байршил, эзэмшил, хяналтын хувь хэмжээ	Ө.Хүдрээ, Гүйцэтгэх захирал Эзэмшиж буй хувьцааны тоо 1000000 ш Эзэмшиж буй хувь 20%

Танилцуулга

"Хай Би Ойл"ХХК нь нефтийн бүтээгдэхүүний импорт, нефтийн бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх зорилгоор 2000 онд байгуулагдсан компани болно. "Хай Би Ойл"ХХК-ий үйл ажиллагааны үндсэн чиглэл нь

1. Нефтийн бүтээгдэхүүний импорт
2. Нефтийн бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа
3. Тос, тосолгооны материалын худалдаа, үйлдвэрлэл
4. Төсөл боловсруулах зэрэг болно

Нэг. Нефтийн бүтээгдэхүүний импорт

"Хай Би Ойл"ХХК нь 2001 оноос эхлэн ОХУ, БНХАУ-аас шатахуун, тос тосолгооны материалыг Монголын зах зээлд нийлүүлэх болсон. Мөн 2003 онд Петровис ХХК, Алтжин ХХК, Глобал Лайн ХХК болон Тас петролеум ХХК-иудаас хил нөхцөлөөр нефтийн бүтээгдэхүүнийг худалдан авч бөөнөөр болон жижиглэнгээр худалдаалж байсан.

Манай компани зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлэх, үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэхэд байнга анхаарч ажилласны үр дүнд гадаад дотоод харилцагчдын тоо нэмэгдсээр байгаа билээ.

2004 оноос манай компани нь ОХУ-ын "Сибнефть" компани, түүний зууч ОХУ-ын "Би-Ойл" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан үр ашигтай ажиллаж байсан.

Хоёр. Нефтийн бүтээгдэхүүний худалдаа

Бөөний худалдаа:

Тус компани байгуулагдсан цагаасаа эхлэн уул уурхайн салбарын болон нефть бүтээгдэхүүний гол гол хэрэглэгч болсон томоохон компаниудтай хамтран ажиллаж түншийн холбоо тогтоон ажиллаж байна. Эдгээр компаниудаас дурдвал:

- ✚ "Золотой Восток Монголия" ХХК
- ✚ "Улаанбаатар төмөр зам"
- ✚ "Монгол газар" ХХК
- ✚ "Багануур" ХК
- ✚ "Шарын гол трейдинг" ХХК
- ✚ "Монголын алт" ХХК
- ✚ "Шивээ-Овоо" ХК
- ✚ "Эрдэс холдинг" ХХК гэх мэт

"Хай Би Ойл" ХХК нь өөрийн харилцагч байгууллагуудын хэрэгцээг найдвартай хангаж, тодорхой хугацаанд харилцан ашигтай хамтран ажилласны үр дүнд улсын болон хувийн хэвшлийн томоохон үйлдвэр, компаниудтай байнгын харилцаа холбоо тогтоож чадсан.

Жижиглэнгийн худалдаа:

Бид 2005 оны 3-р сараас эхлэн түрээсийн шатахуун түгээх станцаараа дамжуулан шатахууны жижиглэнгийн худалдаа явуулж эхэлсэн ба хэрэглэгчдэд чанарын болон стандартын шаардлагад нийцсэн А-80, АИ-93 шатахуун болон Дизель түлшээр хэрэглэгчдэд түргэн шуурхай үйлчилж байна. Мөн метанолын шингэнийг ОХУ-аас импортлон авчирч шатахууны нэмэлт чанар сайжруулагч хэлбэрээр А-80 бензинд хольж стандартын шаардлагыг бүрэн хангасан АИ-92 бензинээр хэрэглэгчдэд үйлчилсэн.

Мөн манай компани үйл ажиллагаагаа өргөжүүлэн уул уурхайн болон эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

Монгол улсын нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээ өмнөх 3 жилд дунджаар 400,0-410,0 мянг.тонн байсан бөгөөд цаашид энэхүү хэрэгцээ улам өсөх хандлагатай байна.

"Хай Би Ойл"ХХК нь Сонгино хайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 8000 метр.квадрат талбай бүхий зориулалтын агуулахтай.


Гурав. Тос, тосолгооны материалын худалдаа, үйлдвэрлэл

2004 онд ОХУ-аас 10 гаруй нэр төрлийн нефть бүтээгдэхүүнийг /Дизель түлш өвөл, зуны, А-80, АИ-93, Трансформаторын тос, Турбины тос ТБ-22, үйлдвэрийн тос И-50А, И-40А, И-30А, И-20А, Гидрийн шингэн АМГ-10, МГЕ-46В, моторын тос М8В, М10В2, М10Г2К, М10ДМ, М10ДМ, түрхлэг тос Графитная, солидол Ж, литол-24, СТП-3/ импортолж дотоодын зах зээлд бөөнөөр болон жижиглэнгээр борлуулсан.

Дөрөв. Төсөл боловсруулах

Манай компани нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаас зарласан тендер, сонгон шалгаруулалтанд идэвхтэй оролцдог бөгөөд энэ ажлынхаа үр дүнд хэд хэдэн тендерийн ялагчаар тодорч тухайн байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж улмаар гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлсэн. Мөн бид "Метанол-Нүүрс дагасан хөгжил" төсөл болон "Ажилласан тос дахин боловсруулах" төслүүдийг боловсруулан, туршилтын ажлыг амжилттай гүйцэтгэсэн билээ. Энэ оны 11-р сараас "Ажилласан тос дахин боловсруулах" төслийн хэрэгжүүлэх шатыг эхлүүлээд байгаа юм.

“Хай Би Ойл” ХК-н удирдлага, зохион байгуулалтын бүтэц



"Хай Би Ойл" ХХК

2006 оны 10 дугаар сар 30

№ 06/12

Улаанбаатар хот

ЗАХИРЛЫН ШИЙДВЭР

№ 06/12

2006 оны 10-р сарын 30


Компанийн өөрчлөн
бүртгэл хангалт

Монгол Улсын Компанийн хуулийн 23-р зүйлийг үндэслэн "Хай Би Ойл" ХХК-ийн өөрчлөн байгуулахаар шийдвэрлэх нь:

1. Компанийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулж, нэг бүрхэлтэс 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 5 000 000 /таван сая/ нэрхэм хувьцааг олгох нийтэд санал болгон гаргасугай.
2. Компанийн дүрмийн санг таван зуун сая төгрөг болон өөрчилсүгэй.
3. "ХайБиОйл" ХХК-ийн 100%-ийн хувьцааг хувьцаат компанийн 20%-ийн хувьцаанд хөрвүүлсүгэй.
4. Компанийн нэр, үйл ажиллагааны үндсэн чиглэл, зүх үүрэг, үүсвэр хадгалагдана.



Ө.Хүдрэг



ГАНЦ ГИШҮҮНТЭЙ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ

КОМПАНИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАХ ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. "Хай Би Ойл" компани (цаашид компани гэх) нь Компанийн тухай Монгол улсын хуулийн дагуу зохион байгуулагдсан хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь энэхүү дүрмээр хязгаарлагдах, хязгаарлагдмал хариуцлагатай компани болно.

1.2. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж, орлого ашгаа арвижуулах замаар хувь нийлүүлэгчдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгоно.

1.3. Компани нь хуулийн этгээдийн эрх эдэлж, бие даасан тайлан тэнцэлтэй буйх бөгөөд тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл мүүдас хэрэглэнэ.

ХОЁР. Компанийн оноосон нэр, оршин байх газрын хаяг.

2.1. Компанийг Монголээр "Хай Би Ойл" ХХК

Англиар "H.B.Oil" Co.,Ltd гэж нэрлэнэ.

2.2. Компанийн төвийн хаяг: СБД,9 – р хороо. 7– р хороолол 31 – 33 тоот

Харилцах утас /факс, имайл/: Шуудангийн хаяг: –

ГУРАВ. Компанийг үүсгэн байгуулагч

3.1. Компанийг үүсгэн байгуулагч нь: Өлзийсайхан Хүдрээ

3.2. Паспорт /иргэний үнэмлэх/, регистрийн дугаар, гэрийн хаяг:

ГД: УБ 0419188, РД: ОЭ 74022477 СБД 9 – р хороо . 31 – 31 тоот

ДӨРӨВ. Компанийн үйл ажиллагааны чиглэл

4.1. Компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ.

Үүнд: 1. Гадаад, дотоод худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл...


4.2. Өрхлөх ажил үйлчилгээний төрөл өөрчлөгдөх тухай шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

4.3. Компани нь өөрийн бүхий л үйл ажиллагаандаа "Компанийн тухай" Монгол улсын хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх эдэлж үүрэг хүлээнэ.

ТАВ. Компанийн өөрийн хөрөнгө, хувьцаа

5.1. Компанийг улсын бүртгэлд бүртгэх үед үүсгэн байгуулагчийн (хувь нийлүүлэгчийн) оруулсан хөрөнгө буюу компанийн өөрийн хөрөнгө нь нийтдээ

1 170.0 мян.төгрөг байна.



5.2. Нэгж энгийн хувьцаа нь 11700 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ...10..... ширхэг байна.

5.3. Хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, алдагдал хариуцах үүргийн хэмжээ болон хуулиар заасан бусад эд хөрөнгийн эрхийг гэрчилсэн үнэт цаас болно. Тус компанийн хувьцаа нэг бүр нь саналын эрхтэй байх бөгөөд энгийн хэлбэртэй байна.

5.4. Компаниас гаргасан хувьцаа нь тэдгээрийг компани худалдан авах буюу эргүүлэн авах, эсвэл бусад төрлийн үнэт цаас, эд хөрөнгөд хөрвүүлэх хүртэл зогсолтанд байна.

ЗУРГАА. Компанийн удирдлага, хяналтын бүтэц

6.1. Компанийг удирдах дээд байгууллага нь түүний хувь нийлүүлэгч болно.

6.2. Компанийн удирдлага дараах асуудлыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ. Үүнд:

- Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах
- Компанийн хэлбэрийг өөрчлөх, өөрчлөн байгуулах, татан буулгах
- Компанийн үнэт цаасыг гаргах
- Хувьцааг хуваах буюу нэгтгэх, компанийн өрийг хувьцаагаар солих
- Тайлан тэнцлийг хэлэлцэж батлах
- Хянан шалгагчийг сонгож тэдний ажиллах нөхцөл, хөлс урамшууллын хэмжээг тогтоох
- Компанийн аудиторыг сонгож гэрээ байгуулах
- Ногдол ашгийн хэмжээг тогтоох, төлөх журмыг батлах
- Компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах
- Компанийн тухай хуулийн 51 –р зүйлд заасны дагуу компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн зах зээлийн үнийг тодорхойлох
- Компанийн бизнес төлөвлөгөөг зохиож батлах
- Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтоох
- Гүйцэтгэх захирал болон хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүдийг томилох, тэдгээрийн бүрэн эрхийг тогтоох, чөлөөлөх
- Гүйцэтгэх удирдлагын гишүүдийн цалин урамшууллыг тогтоох
- Гүйцэтгэх удирдлага болон хянан шалгагчдын ажлын тайланг хүлээж авах, батлах

6.3. Дүрэм болон гэрээгээр тогтоосон эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдуулахаар гүйцэтгэх захиралыг томилон ажиллуулж болно.



- 3.11 Дараахь асуудлуудыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.
- 3.11.1 Компанийн дүрэм батлах, нэмэлт өөрчлөлт оруулах
- 3.11.2 Нийлэх, нэгдэх, хуваах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах
- 3.11.3 Компанийг татан буулгах комиссыг томилох
- 3.11.4 Төлөөлөн Удирдах Зөвлөл, Хянан Шалгах Зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, тэдгээрийн жилийн тайланг батлах
- 3.11.5 Компанийн тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
- 3.11.6 ТУЗ-ийн шийдвэрээр хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэхээр оруулсан бусад асуудлууд
- 3.12 Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.
- 3.13 Компанийн тухай хуулинд зааснаар дийлэнх олонхоор, эсвэл кумулятив аргаар шийдэх асуудлаас бусад тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн асуудлыг ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 3.14 Компанийн дүрэмд тусгайлан заагаагүй бол хурлын тооллогын комисс, санал авах хуудас, түүнийг хүчинтэйд тооцох нөхцөл, эцнээ санал хураалт хийх журам, хурлын тэмдэглэл хийх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд компанийн тухай хуулийг баримтална.

Б. Төлөөлөн Удирдах Зөвлөл

- 3.16 Хувь нийлүүлэгчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/ байна.
- 3.17 Төлөөлөн Удирдах Зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр Хувь нийлүүлэгчдийн хурлаас 1 жилийн хугацаатай сонгож ажиллуулна. ТУЗ-ийн гишүүн нь компанийн хувь нийлүүлэгч биш хувь хүн байж болно.
- 3.18 ТУЗ нь Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад асуудлыг санаачлан хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
- 3.18.1 Компанийн үйл ажиллагааны стратеги болон бизнес төлөвлөгөөг батлах
- 3.18.2 Хувь нийлүүлэгчдийн ээлжит ба ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах болон түүнтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх.
- 3.18.3 Компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах, өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах
- 3.18.4 Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох
- 3.18.5 Компанийн гүйцэтгэх захирлыг томилж гэрээ байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих
- 3.18.6 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, өөрийн хөрөнгөд оруулах өөрчлөлтийн талаар дүгнэлт гаргаж, хувь нийлүүлэгчдийн хуралд оруулан батлуулах

3.18.7 Компанийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах үндсэн үүрэг бүхий Хөрөнгө оруулалтын зөвлөлийг байгуулж ажиллах журмыг нь батлах

3.18.8 Ноогдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлж шийдвэр гаргах

3.18.9 Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах

3.18.10 Компанийг өөрчлөн байгуулах талаар хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх

3.18.11 Компанийн удирдлагыг урамшуулах зорилгоор компанийн хувьцааны энэ дүрэмд заасан хэсгийг менежментэд эзэмшүүлэх талаар шийдвэр гаргах

3.18.12 ТУЗ-ийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, тэдгээрийн цалин урамшууллын хэмжээг ТУЗ-ийн даргын саналаар батлагдсан төсөвт багтааж тогтоох

3.18.13 Гүйцэтгэх захирлын санал болгосноор түүний ажлын аппарат, компанийн бүтэц зохион байгуулалт, орон тоог баталж, цалингийн санг тогтоох, шагнал урамшлын дүрэм баталж мөрдүүлэх

3.19 ТУЗ нь үйл ажиллагааныхаа тайланг жил бүр Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлнэ.

3.21 ТУЗ-ийн гишүүн бүрмөсөн буюу удаан хугацаагаар ТУЗ-ийн гишүүний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд төлөөлөх гишүүнийг дараагийн хувь нийлүүлэгчдийн хурал хүртэл түр томилж болно.

3.22 ТУЗ-ийн ажил үүргээ хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь ТУЗ-ийн хурал байх ба сард нэгээс доошгүй удаа хуралдана. ТУЗ-ийн 6-аас доошгүй гишүүн хуралд оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцох ба зайлшгүй шаардлагын улмаас ТУЗ-ийн гишүүн хуралд биеэр оролцож чадаагүй тохиолдолд урьдчилан хурлын хэлэлцэх асуудалтай танилцсаны үндсэн дээр саналаа бичгээр ирүүлж хуралд оролцож болно.

ТУЗ эцнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

3.23 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүд, компанийн гүйцэтгэх удирдлага болон Хянан галгах зөвлөлийн санаачлага шаардлагаар хуралдуулна.

3.24 ТУЗ-өөр хэлэлцсэн асуудлыг гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Шийдвэрлэсэн асуудлаар ТУЗ-ийн хурлын тогтоол гаргаж зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

3.25 ТУЗ-ийн хурлаас ТУЗ-ийн даргыг сонгоно. ТУЗ-ийн дарга нь компанийн Гүйцэтгэх захирал байж болохгүй.

3.26 ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсвэл ТУЗ-ийн шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

3.27 ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, гаргасан шийдвэрт хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

3.28 ТУЗ-ийн дарга нь гүйцэтгэх удирлагыг томилох, чөлөөлөх саналыг ТУЗ-ийн хуралд оруулах, ТУЗ-ийн шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих, ТУЗ-ийн төсвийг хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

3.29 ТУЗ нь хурлаасаа сонгосон орон тооны бус нарийн бичгийн даргатай байх бөгөөд нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн гишүүн бус харин удирдах багийн гишүүн байж болно.

3.30 Нарийн бичгийн дарга нь хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх, хурлын зар, товыг мэдээлж, хурлаас гарах шийдвэрийн төслийг бэлдэж тараах, тэмдэглэл хөтлөх, бичиг хэрэг нууц хадгалалтыг хариуцна.

В. Гүйцэтгэх захирал

3.31 Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм, ТУЗ-тэй байгуулсан гэрээгээр олгогдсон эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

3.32 ТУЗ-ийн дарга буюу 3-аас доошгүй гишүүн нэгдэн санал болгосноор нэр дэвшүүлж, ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэнээр ТУЗ нь Гүйцэтгэх захиралтай 2 жилийн хугацаатай гэрээ байгуулж, түүний эрх үүрэг, хариуцлага, цалин урамшуулал зэрэг асуудлыг шийдвэрлэнэ.

3.33 Гүйцэтгэх захирал дараах эрх үүрэгтэй байна.

3.33.1 ТУЗ-өөс олгосон эрх хэмжээнд компанийн өмчийг захиран зарцуулах ба компанийн өөрийн хөрөнгийн 10%-аас дээш хэмжээний гэрээ хэлцэл болон бусад аливаа шийдвэрийг ТУЗ-ийн хурлаар оруулан зөвшөөрсөн тохиолдолд хийх эрхтэй.

3.33.2 ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэхгүйгээр үйл ажиллагаа явуулах

3.33.3 ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах

3.33.4 Компанийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулж ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ хэлцэл байгуулах, ажлын дотоод журмыг хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг хамтын гэрээ, хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулна.

3.33.5 Санхүүгийн үйл ажиллагааг биечлэн удирдаж, санхүүгийн тайлан бүртгэлд хяналт тавина.

3.33.6 Хувь нийлүүлэгчдийн хурал, ТУЗ, Хяналтын байгууллагад гаргасан компанийн үйл ажиллагааны тухай мэдээ, мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

3.33.7 ТУЗ-ийн зөвшөөрлөөс бусад тохиолдолд компанийн нууц мэдээг гуравдахь этгээдэд дамжуулах, хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.

3.33.8 ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай санал гаргана.

3.33.9 Гүйцэтгэх захирлын ажлын аппарат, менежментийн багийг бүрдүүлж ажиллана.

Г. Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хүлээх хариуцлага

3.34 Эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн дарга, гишүүд, компанийн Гүйцэтгэх захирал, ерөнхий менежер болон ажлын аппаратын зохих албан тушаалтнууд хамаарна. Эрх бүхий албан тушаалтанд хамаарах ажлын албаны албан тушаалтнуудын жагсаалтыг ТУЗ-ийн хурлаас батална.

3.35 Хуульд өөрөөр заагаагүй бол компанийн эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас компанид учирсан хохирлыг хариуцна. Эрх



бүхий албан тушаалтан компанийн дотоод журам, үүргийн хуваарийн дагуу ажиллах ба компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана. Эрх бүхий албан тушаалтан компанийн нууц мэдээг гуравдахь этгээдэд дамжуулах, хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.

3.36 Эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас /үүнд бизнесийн эрсдэл үл хамаарна/ компанид учруулсан хохирлыг өөрөө бүрэн хариуцна.

3.37 Компанийн эрх бүхий албан тушаалтан түүний эрх үүргийн хэм хэмжээ, түүнд тооцох хариуцлагыг тусгай журам болон хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.

Дөрөв. Компанийн хяналт, бүртгэл, тайлан, ашиг хуваарилалт

А. Нягтлан бодох бүртгэл, тайлан, ашиг хуваарилалт

4.1 Компани нь нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах бөгөөд хувь нийлүүлэгчдийн хурал, татварын байгуулга, Санхүүгийн Зохицуулах Хороонд хуулинд заасан хугацаанд танилцуулж мэдээлнэ.

4.2 Компанийн санхүүгийн тайланд дараахь зүйлийг тусгана

4.2.1 Баланс

4.2.2 Орлого, үр дүнгийн тайлан

4.2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

4.2.4 Хуримтлагдсан ашгийн тайлан

4.2.5 Нэмэлт тайлан

4.2.6 Бусад

4.3 Компани нь жил бүрийн үйл ажиллагааны цэвэр ашгийг төсөвлөж зарцуулна. Үүнд: Урт богино хугацааны хөрөнгө оруулалт, компанийн ажиллагсдын нийгмийн асуудал, шагнал, урамшил, компанийн эрх бүхий албан тушаалтанд олгох шагнал урамшуулал, компанийн хувь нийлүүлэгч нарт олгох ноогдол ашиг зэрэг болно.

4.4 Компанийн жилийн цэвэр ашгийн 20-оос доошгүй хувиар ноогдол ашиг хуваарилж байна.

Б. Аудитор

4.5 Компани нь санхүүгийн тайланг шалгуулах, баталгаажуулах, аж ахуйн үйл ажиллагааны бүрэн эсвэл хэсэгчилсэн шалгалт хийх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг ажиллуулна.

4.6 Аудиторын ээлжит шалгалтаар компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулна. Ээлжит бус аудиторын шалгалтыг ТУЗ, 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийлгэж болно.

4.7 Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичиг танилцуулах үүрэгтэй.

В. Хянан шалгах зөвлөл

4.8 Хянан шалгах зөвлөл нь компанийн Дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих компанийн удирдлагын үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргаж хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулах, хувь нийлүүлэгчдийн санал гомдлын дагуу компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгана. Хянан шалгах зөвлөл нь хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурал хуралдуулахыг шаардах эрхтэй.

4.9 Хянан шалгах зөвлөлийг хувь нийлүүлэгчдийн хурлаас 1 жилийн хугацаатай сонгоно. Хянан шалгах зөвлөлийн гишүүн нь компанийн эрх бүхий албан тушаалтан буюу түүний нэгдмэл сонирхолтой этгээд байхыг хориглоно. Харин хувь нийлүүлэгч байж болно.

4.10 Хянан шалгах зөвлөлийн шаардсанаар компанийн бүх шатны албан тушаалтан хяналт, шалгалтанд шаардлагтай баримт бичиг, мэдээ тайланг саадгүй гаргаж өгнө.

4.11 Хянан шалгагч нь хяналт, шалгалт хийсэн тухай дүгнэлт, шийдвэрээ Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулах, хувь нийлүүлэгчдийн хуралд тайлагнах үүрэгтэй.

4.12 Хянан шалгах зөвлөл нь 3 гишүүнтэй байх бөгөөд зөвлөлийн даргыг хянан шалгах зөвлөлийн хурлаас сонгоно.

4.13 Хянан шалгах зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж байна.

Тав. Компанийг татан буулгах

5.1 Компанийг хувь нийлүүлэгчдийн болон шүүхийн шийдвэрээр хуульд заасан үндэслэлээр татан буулгана. Компанийг татан буулгах үед хуульд заасан өр төлбөрийг нь барагдуулах, хувь нийлүүлэгчдэд эд хөрөнгийг нь хуваарилах ба бусад асуудлыг шийдвэрлэнэ.

Зургаа. Бусад зүйлс

6.1 Энэхүү дүрмэнд заагаагүй эрх зүйн харьцаануудыг холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Энэхүү Дүрэм нь хувь нийлүүлэгчдийн хурлаар баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж үйлчилнэ.

“ХАЙ БИ ОЙЛ” ХУВЬЦААТ КОМПАНИ





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2008 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 18.

Улаанбаатар хот

Үнэт цаас нэмж
бүртгэх тухай


СЗХ-ны 2007 оны 11 дүгээр сарын 29-ний 182 тоот тогтоол, “Хай Би Ойл” ХК-ийн 2007 оны 12 сарын 04-ний өдрийн 21 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн шалгалтын тайлан, 2008 оны 01-р сарын 23-ны өдрийн Захирлын зөвлөлийн хурлын протоколыг үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. “Хай Би Ойл” ХК-ын нэмж гаргаж буй нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2.0 сая ширхэг хувьцааг Монголын хөрөнгийн биржийн бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтанд бүртгэсүгэй.
1. Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Хай Би Ойл” ХК-ийн захирал /Ө.Хүдрээ/-д үүрэг болгосугай.
2. “Хай Би Ойл” ХК-ийн Монгол улсын хууль тогтоомж, зах зээл дээр мөрдөгдөж буй журам заавар, “Үнэт цаас гаргагчтай байгуулах гэрээ”-гээр хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг БХА-ны захирал /Ц.Цэндмаа/, Андеррайтер, брокер дилерийн “Би Ди Сек” ХК-ийн захирал /Д.Даянбилгүүн/ нарт үүрэг болгосугай.




ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

P.СОДХҮҮ



**“ ХАЙ БИ ОЙЛ “ ХК-ийн
нэмэлт хувьцаа гаргах
товч танилцуулга**

Улаанбаатар хот
2007 он



ГАРЧИГ

1. Ажилласан, суурь болон техникийн тосны талаар товч ойлголт	2
2. Ажилласан техникийн тос дахин цэвэршүүлэх үйлдвэрийн тухай товч ойлголт	3
3. Ашигласан тосыг дахин боловсруулах арга технологиуд	4
4. Хувьцаа нэмж гаргах болсон шалтгаан	5
5. Анхны хөрөнгө оруулалтын зарцуулалтын тайлан	6
6. Нэмж гаргасан хувьцааны орлогын зарцуулалтын төлөвлөгөө	6
7. Үйлдвэрийг бүтээн босгох график төлөвлөгөө	7
8. Dunwell үйлдвэрийн тухай	8
9. Ашигласан тосыг шүүж цэвэрлэх үйлдвэрийн зарчмын схем	9
10. Эдийн засгийн үр ашгийн тооцоо	10
- Хөрөнгө оруулалтын тооцоо	
- Хөрөнгө зарцуулалтын тооцоо	
- Төлөвлөсөн орлогын тооцоо	
- Төлөвлөсөн ашгийн нэгдсэн тооцоо	
- Бүтээгдэхүүний өртгийн нэгдсэн тооцоо	
- Цалингийн зардлын тооцоо	
- Цахилгааны зардлын тооцоо	
- Үйлдвэрлэлээс гарах бүтээгдэхүүнүүд, түүний одоогийн зах зээлийн үнэ	



Ажилласан, суурь болон техникийн тосны талаар товч ойлголт

